



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн гэр хорооллын хороодод гарч байгаа ил задгай галаас үүдэлтэй гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор зориулалтын тагтай үнсний сав хийлгэж төвийн 6 дүүргийн гэр хорооллын хороодын өрхүүдэд олгох ажлыг зохион байгуулсугай.
2. Зориулалтын тагтай үнсний сав хийх зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Үнсний сав хийхэд шаардагдах 3.540.000 (гурван сая таван зуун дөчин мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.
4. Зориулалтын тагтай үнсний савыг хийлгэж, төвийн зургаан дүүргийн гэр хорооллын 120 өрхөд олгох ажлыг зохион байгуулахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



D:/My documents-blank-2019-tushaal

00115050 969

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
#133 дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТӨВИЙН 6 ДҮҮРГИЙН ГЭР ХОРООЛЛЫН ХОРООДЫН ӨРХҮҮДЭД  
ОЛГОХ ЗОРИУЛАЛТЫН ТАГТАЙ ҮНСНИЙ САВ ХИЙХ АЖЛЫН ТЭСӨВ

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт /төгрөг/
1	Төмөр торх /200 литрийн багтаамжтай/	ш	9.500	120	1.140.000
2	1,2 мм-ийн листэн төмөр	м	20.000	120	2400.000
Нийт					3.540.000

---oOo---